



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/155

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 03/04 дүгээр тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэлний бодлогын Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Хэлний бодлогын салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, ажиллах төлөвлөгөө боловсруулан, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” хөтөлбөрийг хэрэгжүүлж, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн албан хаагч, иргэдэд монгол бичгийн сургалт зохион байгуулах, албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаягийг монгол бичгээр бичиж хэвшүүлэхийг сумын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Аймгийн хэлний бодлогын Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах 3,100,000 (гурван сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар Санхүү төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100336

Аймгийн Засаг даргын 2021 оны...⁰⁴
 дугаар сарын 02-ны өдрийн ...^{1/35} дүгээр
 захирамжийн хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

д/д	Шагнал	Тэргүүн байр		Дэд байр		Гутгаар байр		нийт	
		тоо	шагнал	тоо	шагнал	тоо	шагнал	тоо	шагнал
1	Аймгийн “Тэргүүний хэлний бодлогын зөвлөлийн салбар зөвлөл” шалгаруулах	1	500,000	1	300,000	1	200,000	3	1,000,000
2	“Үндэсний бичиг үсгээ эрхэмлэгч байгууллага хамт олон”	1	300,000	1	200,000	1	100,000	3	600,000
3	“Үндэсний бичиг үсгээ эрхэмлэгч албан хаагч”	1	200,000	1	150,000	1	100,000	3	450,000
4	“Үндэсний бичиг үсгээ түгээгч багш”	1	200,000	1	150,000	1	100,000	3	450,000
5	Батламж, өргөмжлөл	4	200,000	4	200,000	4	200,000	12	600,000
Нийт			1400,000		1000,000		700,000		3,100,000

-оОо-